



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 07 сарын 24 өдөр

Дугаар А/405

Есөнбулаг сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь заалт, 50 дугаар зүйлийн 50.1.2 дахь заалт, 50 дугаар зүйлийн 50.4, 50.5 дахь хэсгүүд, Сангийн сайдын 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/100 дугаар тушаалаар батлагдсан "Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, урамшууллын журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Солонго дулааны станц ААТҮГ-ын урсгал төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх "Солонго дулааны станц ААТҮГ-т 2026-2027 онд хэрэглэгдэх нүүрс" нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга	Д.Буянхишиг	(Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтсийн дарга)
Гишүүд	3.Жаргалтуяа	(Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн)
	Ш.Батзүсэм	(Хөндлөнгийн төлөөлөл) (тохиролцсон)
	Ц.Зоригт	(Иргэний төлөөлөл) (тохиролцсон)
Нарийн бичиг	Ч.Мэндбаяр	(Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2.Тендерийн баримт бичгийг боловсруулж батлуулан, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу шуурхай зохион байгуулж, үр дүнг танилцуулахыг үнэлгээний хороо (Д.Буянхишиг)-нд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ